

17 ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ТЭРЭЛЖ СУУРИН

Д. ХИШИГДОРЖ, Г. УРАНТАМИР, Ш. АМАНГҮЛ,
Ц. ОТГОНХҮҮ, Б. НАЦАГСҮРЭН

d_dorjoo86@yahoo.com, ГЗХ, ШУА

Terelj Settlement and population

The paper provides strength and opportunity of development of the small size settlement in current socio economic transition period of Mongolia. The study was conducted in area where rapid infrastructure development is observed due to close location to large town, intensive migration increases a population densities and change the landscape of small settlement development in peri-urban area. Analyses indicate that tourism industry play not the least role in development of Terelj settlement.

Түлхүүр үгс: *Хүн амын суурьшил, суурины үүрэг, аялал жуулчлал, социологийн асуулга*

17.1 ОРШИЛ

Байгальтайгаа зохицон хөгжих үзэл баримтлал давамгайлж буй өнөө үед байгалийн нөөц баялгийг шинжлэх ухааны үндэстэй ашиглах нь чухал ач холбогдолтой бөгөөд байгалийн баялгийг хэрхэн ашиглаж байгаа нь жижиг суурины хөгжилд шийдвэрлэхүйц нөлөө үзүүлдэг (Hinderink and Titus, 2002).

Улаанбаатар хотын хүн ам өсөхийн хирээр хотыг тойрсон аялал жуулчлал, амралт сувиллын газар, хувийн орон сууц, зуслангийн чиглэлтэй сууринууд олноор нэмэгдэж (Жамсансүрэн, 2003; НЭЗГС, 2013), хот орчмын хүн амын нутагшилтад нөлөөлөн, суурьшлын шинэ хэлбэрүүдийг үүсгэж (НЭЗГС, 2007) байна. Судалгаанд хамрагдсан Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын бүс нутагт зөвхөн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд шинээр 22 том, жижиг аялал жуулчлалын бааз байгуулагдсан бөгөөд түүнийг даган олон жижиг суурин, суурьшлын цэгүүд үүсжээ. Энэхүү үйл явцыг нийгмийн хөгжилд нийцүүлэн хүн амын нутагшилтын асуудлыг үр дүнтэй удирдан хөгжүүлэх нь хот суурины хөгжлийн тулгамдсан асуудал болоод байна. Тус өгүүлэлд Тэрэлж суурины гүйцэтгэж буй үүрэг болон аялал жуулчлалыг түшиглэн хөгжиж буй хандлагыг тодорхойлсон болно.

17.2 СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ


Тэрэлж суурины 38 өрхөөс социологийн асуулгыг анкетын аргаар явуулж, мэдээллийг тоон үзүүлэлт руу кодлон, MS.Excel программыг ашиглан шивж, мэдээллийн сан үүсгэн, дүн шинжилгээ хийсэн. Тус суурины 153 айлын хашаа хорооны бүртгэлийг хийн, байр зүйн зурагт буулган, дараа нь Google earth-н сансрын зурагтай давхцуулж, ArcGIS программыг ашиглан гэр хорооллын бүдүүвч зураг зохиосон. Олон нийтийн мэдээллийн сүлжээ болон Налайх дүүргийн 6-р хорооны улсын бүртгэгчээс статистик мэдээ материал цуглуулж, анхан шатны боловсруулалтыг 2003-2013 онуудаар харьцуулж дүн шинжилгээ хийсэн болно.

17.3 ҮР ДҮН

Тэрэлж голын сав газрын хамгийн том суурин болох Налайх дүүргийн 6-р хорооны төв Тэрэлж тосгон (суурин) Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын өмнөд хэсэгт, Улаанбаатар хотоос 70 км, Налайх дүүргээс 40 км зайд 130.3 га (1.3 км²) нутгийг эзлэн оршино.

Улс ардын аж ахуйд мод бэлтгэлийн үүрэгтэй 1960-аад онд байгуулагдсан ч үүргийн бүтэц нь аажмаар өөрчлөгдөн, амралт сувиллын үүрэг (Баянтөр 2003)-тэй болсон ба 1990-ээд оноос хойш үүрэг, бүтцээ өөрчлөөгүй хадгалж үлдсэн цөөхөн суурины нэг юм.

Тэрэлж суурин 259 өрхийн 631 хүн амтай (2013 он). Нийслэл хотын хөдөөгийн бүсэд байрлалтай, дэд бүтцийн хөгжил сайтай, аялал жуулчлалын бүс нутаг зэрэг таатай нөхцөл (Баяртогтох, 2007)-ийг даган хүн амын тоо жил ирэх тутам өсөж байна. Тухайлбал 2008 оноос хойш суурины хүн ам 27.5 хувиар, өрхийн тоо 37.8 хувь (зураг 17.1)-иар өсжээ.



Зураг 17.1 Тэрэлж суурины хүн амын тооны өөрчлөлт (2008-2012) (Эх сурвалж: Налайх дүүргийн статистикийн эмхэтгэл, 2014 он)

Нийт хүн амын 27.3 хувийг 15 хүртэл насны хүүхдүүд, 61.3 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 11.4 хувийг 60-аас дээш тэтгэврийн насныхан эзэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амын 48 хувь нь ажиллагчид, 22 хувь нь ажилгүйчүүд, 5 хувь нь группэд, 21 хувь нь тэтгэвэрт, 4 хувь нь оюутан сурагч байна. Мөн нийт өрхийн 7 хувь чинээлэг, 26.1 хувь боломжтой, 50.4 хувь дундаж, 16.5 хувь ядуу гэсэн статистикийн тоо баримт (ҮСГ, 2014) байдаг.

Социологийн асуулгад хамрагдсан өрхийн 56 хувь нь шилжиж ирсэн ба 37.5 хувь нь Улаанбаатар хотоос, 25 хувь нь Хөвсгөл, 25 хувь нь Баянхонгор, 12.5 хувь нь бусад аймгуудаас хөдөлмөр эрхлэх (41 хувь), өрхийн орлогоо нэмэгдүүлэх (36 хувь), цэвэр агаарт амьдрах (10 хувь), зах зээлд ойртох (8 хувь), суурин газар бараадах болон бусад шалтгаан (5 хувь)-ы улмаас шилжиж иржээ. Шилжин ирэгчдийн дийлэнх нь (88.9 хувь) 40-өөс дээш насныхан байна.

Тэрэлж суурин төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, Улаанбаатар хот, Налайх дүүрэгтэй хатуу хучилттай авто замаар холбоотой бөгөөд Налайх дүүрэг рүү 2 цаг тутамд микро автобус, Улаанбаатар хот руу өдөрт 2 удаа том оврын автобус явж оршин суугчдад үйлчилдэг. Бага сургууль,

цэцэрлэг, өрхийн эмнэлэг, хорооны засаг захиргааны төв, Хаан банк болон 7 хүнс, барааны дэлгүүр, 3 цайны газар зэрэг үйлчилгээний цэгүүд ажиллаж байна.

Нийт ажиллагчдын 2.6 хувь нь төрийн захиргаа, 3.9 хувь нь төрийн үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд), 40.5 хувь нь үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт ажилладаг. Үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын 52.4 хувь нь жуулчны бааз, хувиараа гэр буудал, морь унуулах үйлчилгээ зэрэг жуулчидтай шууд харьцдаг үйлчилгээ, 47.6 хувь нь худалдаа үйлчилгээ, зоогийн газар зэрэг шууд бус харьцдаг салбарыг ажиллуулж байна.



Зураг 17. 2 10 сар хүргээд үйл ажиллагаагаа зогсоосон гэр буудлын гэрийн буурь



Зураг 17. 3 Тэрэлж суурингийн хүн амын суурьшлын хэлбэр (Эх сурвалж: Хээрийн судалгааны материал 2014)

Тэрэлж голын сав газар 24.5 мянган толгой малтай (2013 он)-гаас 32.8 хувь нь Налайх дүүргийн 6-р хороо буюу Тэрэлж суурин болон суурины орчимд байршина. Нийт мал сүргийн 35 хувийг хонь, 28.7 хувийг ямаа, 26.1 хувийг үхэр,

10.1 хувийг адуу, 0.1 хувийг тэмээ эзэлнэ. 2012-2013 онд тус суурины малын тоо 16.1 хувь (1549)-иар буурсан боловч үхрийн тоо толгой 0.3 хувиар өсжээ. Энэхүү байдал аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд шууд ба шууд бус байдлаар хөдөөгийн иргэд оролцон, ашиг хүртэн, орлого нэмэгдүүлэн, аж амьдралаа дээшлүүлж буйтай холбоотой юм.

Малтай иргэд 6-р сараас 9-р сарын хооронд жуулчны баазуудын орчим нүүж ирэн, жуулчид, амрагчдад морь хөлслүүлж унуулах, сүү, цагаан идээ, мах нийлүүлэх байдлаар аялал жуулчлалын салбараас ашиг олдог байна. Тэрэлж суурины ойролцоо морь унуулдаг 30-40 иргэдээс 5-10 нь томоохон жуулчны баазуудтай гэрээ хийн, жуулчдад морио унуулдаг байна.

Улаанбаатар хотын иргэдийн амарч, үйлчлүүлэх өдөр тутмын давтамжтай хөдөлгөөний хэлбэр зонхилох болсноор гэр буудлуудын тоо нэмэгдэж, 2013 онд 51 гэр буудал үйл ажиллагаа явуулжээ. Гэр буудлуудыг суурины иргэд болон суурин орчим нутагладаг малчид нөхөрлөл байгуулан ажиллуулдаг ба улирлын чанартай (5-р сараас 10-р сар хүртэл) юм. Ингэснээр суурины амралт сувиллын үүрэг улам нэмэгдэж (зураг 17. 2) байна.

Гэр буудлуудын тоо өсөхийн хэрээр байгальд орчинд үзүүлж буй сөрөг нөлөө нэмэгдэн, байгаль орчны бохирдол, экологийн тэнцвэрт байдал алдагдаж (Жамсансүрэн, 2003) байна. Тухайлбал, хог хаягдал, гол, горхины усны бохирдол, хөрс болон бэлчээрийн доройтлоос гадна газар сайгүй эмх замбараагүй хашаа хатгаснаар суурины өнгө төрх ихээхэн өөрчлөгдөж байна. Тус суурины хүн амын өсөлтийг даган гэр хорооллын суурьшлын талбай мөн нэмэгдэж байна. Суурьшлын бүсийн талбай 2003 онд 32.5 га, 2008 онд 41.2 га, 2013 онд 130.3 га болж 2003-2013 оны хооронд 301 хувиар (зураг 17. 3) өсжээ.

Нийт 153 өрхийн хашаа хорооны бүртгэлийг хийхэд нийт өрхийн 32.8 хувь уламжлалт сууц гэрт, 67.2 хувь байшинд амьдарч байгаа ч нийт өрхийн 39.2 хувь нь жилийн турш амьдардаг, 41.8 хувь зуслангийн зориулалтаар хотоос ирж, зундаа амьдардаг, 19 хувь зундаа зусаж, бусад улиралд өөр бууц дээр буудаг нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малтай өрхүүд байна.

Эндээс Тэрэлж сууринд хүн ам суурьшлын хоёр хэлбэр зонхилсон нь харагдаж байна. Үүнд:

- а) Жилийн дөрвөн улиралд амьдардаг, ажил хөдөлмөр эрхэлдэг болон том хотоос зундаа ирж зусдаг, улирлын чанартай аж ахуй эрхэлдэг тогтвортой суурьшил
- б) Зундаа ирж зусан, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүдийн тогтворжих суурьшил

Мөн суурин газрын улс орны нийгэм эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг нь хүн амын тоо, аж ахуйн бүтцээс шууд хамаардаг. Тэрэлж сууринд хэд хэдэн бүлэг үүрэг илэрч байна. Үүнд:

- а) Амралт сувилал, хөдөө аж ахуйг хослуулсан үүрэг
- б) Үйлчилгээний (орон нутгийн засаг захиргаа, худалдаа, боловсрол, эрүүл мэнд) үүрэг

Эдгээр үүрэг нь хот орчмын бүс нутагт орших суурин газрын гүйцэтгэх түгээмэл үүрэг боловч Тэрэлж суурины хувьд аялал жуулчлал нь илүү давамгайлсан байдгаараа ялгаатай юм.

ДҮГНЭЛТ

- Тэрэлж сууринд амралт сувиллын үүрэг зонхилсон нь тус бүс нутгийн аялал жуулчлалд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг.
- Тус сууринд газар ашиглалтын хувьд аялал жуулчлалын үйл ажиллагаа давамгайлж буй боловч уг үйл ажиллагаанд малчид ил буюу далд хэлбэрээр оролцдог суурьшлын бүс болж байна.
- Тус суурины хүн амын тоо жил ирэх тутам тогтмол өсөж байгаа бөгөөд цаашид үргэлжлэн өсөх хандлага ажиглагдаж байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

- Баянтөр М. (2003) Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хот орчмын зарим суурины үүргийн бүтцэд гарч буй өөрчлөлтүүд. *МУИС Газарзүйн асуудлууд*, 3
- Баяртогтох Д. (2007) Төв тэнхлэгийн дагуух хотжилтын үйл явцын хүрэн дэх аялал жуулчлалын нөлөөлөл, цаашдын хөгжлийн асуудалд. *Монгол Орны Газарзүйн Асуудал*, 5,
- Жамсансүрэн Н. (2003) Хот орчмын аялал жуулчлал хөдөөгийн хүн амын тогтвортой хөгжлийн тулгуур мөн. *МУИС Газарзүйн асуудлууд*, 3
- Hinderink J, Titus M (2002) Small Towns and Regional Development: Major Findings and Policy Implication from Comparative Research. *Urban Studies*, 39: 379 DOI: 10.1080/00420980220112748
- “Монгол орны хүн амын нутагшилт, хотжилтын орчин үеийн асуудал” сэдэвт ажлын тайлан (2005-2007)
- “Монгол орны төв бүсийн нийгэм-эдийн засаг, физик газарзүйн иж бүрэн тодорхойлолт” сэдэвт ажлын тайлан (2011-2013)
- Налайх дүүргийн статистикийн эмхэтгэл 2013
- “Хүн амын нутагшил, суурьшлын орон зайн зүй тогтол” сэдэвт ажил (2014-2016)-ын хээрийн судалгааны материал